

**"ХИШИГ-УУЛ" ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл**

2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

"Хишиг-Уул" ХК ("Компани" гэх)-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3-р хороонд байрлах "Peace tower"-ын 9 давхар 905 тоот байранд 15:10 минутад эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 21.69%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Я.Нэргүй, Ц.Роза биеэр, 63.2%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Б.Энххорлоо, Г.Байгалмааг итгэмжлэлээр төлөөлж Я.Нэргүй, Нийслэлийн Өмчийн Ашиглалт, Удирдлагын газрыг төлөөлөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч С.Даваасүрэн нар итгэмжлэлээр оролцож байгаа бөгөөд нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 84.89%-ийн ирцтэйгээр оролцож байгаа болохыг мэдэгдэж байна. Ийнхүү Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хурал хүчин төгөлдөр ирцтэй эхэлж байна.

Хурал даргалагч Я.Нэргүй хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцуулж, хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлав. Хэлэлцэх асуудлын жагсаалт:

Нэг. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Хоёр. Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Гурав. Компанийн 2022 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;

Тав. "Хэрлэн" худалдааны төвийн дээврийн капитал их засварын ажлын хөрөнгө оруулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

Нэгдүгээр асуудал. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Хурал даргалагч Я.Нэргүй Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Я.Нэргүй: Манай компани нь 2020 болон 2021 онд дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахлын хүнд үеийг Засгийн Газраас хэрэгжүүлсэн тэтгэвэр, нийгмийн даатгал, цахилгаан, дулааны зардлуудыг хөнгөлсөн хөнгөлөлтүүдэд Нийслэлийн өмчийн 34%-ийн оролцоотой гэдэг шалтгаанаар хамрагдаж чадаагүй хүндрэлтэй даван туулсан. Ялангуяа 2021 оны эхний хагас жил их хүнд байсан, 2021 оны хоёрдугаар улирлаас хойш бол Засгийн газраас олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, эргэлтийн хөрөнгө, бараа эргэлтийг сайжруулснаар үйл ажиллагаа идэвхжиж, дээшилсэн. 2021 онд нийт борлуулалтын орлого 1,4 тэрбум төгрөг буюу 2020 оны борлуулалтын орлого болох 1,2 тэрбум төгрөгөөс нэмэгдсэн боловч ашиг эрс буурсан. Ашиг буурсан явдал нь өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, худалдан авагчдын худалдан авах чадвартай холбоотой гэж үзэж байна. 2021 онд үйлчлүүлэгч ард иргэдэд үйлчилгээгээ сайжруулахын тулд "Хэрлэн" худалдааны төвийн авто зогсоолыг өргөтгөж, тохижуулсан. Татварын дараах цэвэр ашиг 5,5 сая төгрөг байна.

Хоёрдугаар асуудал: Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн хувьцаа эзэмшигч Ц.Роза Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Ц.Роза: Компани нь 2021 онд 30 гаруй ажиллагсадтайгаар Супермаркет дэлгүүр, ажлын байрны түрээс, зоогийн газар гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Санхүүгийн тайланг санхүүгийн байдал, үйл ажиллагааны орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан гэсэн 4-н төрлөөр бэлтгэж гаргасан ба балансын тоон үзүүлэлтүүд нь төгрөгөөр илэрхийлэгдсэн. Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн.

Эргэлтийн хөрөнгө 235,932,194.87 мөнгө, үндсэн хөрөнгө 668,273,888.00 төгрөг, урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625.25 мөнгө Нийт хөрөнгийн дүн 1,363,831,708.12 мөнгө болно. Нийт үндсэн хөрөнгийн дүн 964,433,731.00 төгрөгөөс хуримтлагдсан элэгдэл 296,159,843.00 төгрөгийг хасаад үлдэх өртөг нь 668,273,888.00 төгрөг болно. Урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625.25 мөнгө байгаа нь үндсэн хөрөнгийн их засварын зардал бөгөөд барилга байгууламж дээр капиталжуулах ёстой. Нийт өр төлбөрийн дүн 646,508,857.27 мөнгө үүнээс урт хугацаат зээл 267,202,344.27 мөнгө. Богино хугацаат өр 379,306,512.80 мөнгө, эздийн өмч 717,322,850.85 мөнгө. Өр төлбөр ба эздийн өмчийн нийт дүн 1,363,831,708.12 мөнгө байна. Богино хугацаат өр төлбөрөөс 44,282,632.84 мөнгө нь татварын өглөг 334,354,301.96 мөнгө нь дансны өглөг юм.

Компани нь 2019 онд 1,652,883,458.97 мөнгөний орлого олсноос Борлуулалтын өртөг 1,154,287,713.60 мөнгийг хасаад нийт ашиг 498,595,745.37 мөн үүнээс 515,338,542.46 мөнгөний ерөнхий ба удирдлагын зардлыг хасахад 16,742,797.09 мөнгөний алдагдалтай ажилласан болно. Зардал өссөн нь дулаан цахилгаан, цэвэр бохир усны үнэ 10% өссөнтэй холбоотой. Компани нь 2021 онд 1,407,293,900 борлуулалтын орлого олсон байна. Харин 2021 оны нийт ашиг нь 6,122,600 байна. Өмч 86,825,000.00 төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 658,460,091.00 төгрөг эздийн өмч 83,645,405.00 төгрөг хуримтлагдсан ашиг 125,556,300 мөнгө Өмчийн өөрчлөлтийн нийт дүн 702,374,100 мөнгө Компани нь 2021 онд 6,122,600 төгрөгийн ашигтай ажилласан дүгнэлт гарсан байна.

Гуравдугаар асуудал: Компанийн 2022 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

Ц.Роза: Хамгийн гол ажил нь дээврийн засварын ажил байгаа.

Я.Нэргүй: Хурлаар танилцуулж буй бизнес төлөвлөгөөнд тусгагдсан арван дөрвөн ажлыг хийхээр төлөвлөж байна.

С.Даваасүрэн: 108 м³ гүн хөлдөөх камер шинээр авч байгаа юм уу?

Я.Нэргүй: Манайх хуучин уг нь камер байсан, тэрийгээ шинэчлэх гэж байгаа юм.

С.Даваасүрэн: Тэрийгээ доор хийх гээд байна уу?

Я.Нэргүй: Хөлдөөгч камер хуучин байсан, мотор цохисон, шинэчлэх шаардлагатай байгаа тул бизнес төлөвлөгөөнд тусгасан.

С.Даваасүрэн: Ер нь анхнаасаа 108 м³ хэмжээтэй байсан юм уу?

Я.Нэргүй: Тийм. Хуучин байсан.

С.Даваасүрэн: Тэрийгээ л шинээр авч засварлах гэж байгаа юм байна тийм үү? Шинээр суурилуулах гэсэн байгаа тул лавлаж байгаа юм.

Я.Нэргүй: Тоног төхөөрөмж шинээр суурилуулах гэдэг утгаар нь оруулсан байгаа.

Ц.Роза: Дээр үеийн тог их иддэг нүсэр юм байгаа. Тэрийгээ одоо боломжоороо ашиглалтад оруулна гэж байгаа.

С.Даваасүрэн: “Анхилуун”-аа Та бүхэн цааш нь ажиллуулна гэж байгаа юм уу? Өөрчилнө гэж яригдаад байсан?

Ц.Роза: Өөрчлөлт хийх гэж байсныгаа больсон. Засварын зардал хэтэрхий их байсан.

С.Даваасүрэн: Юу болгох гэж байсан юм бэ?

Ц.Роза: Анхилууныг өөрчлөөд таван хэсэгт хуваагаад цэцэрлэг маягийн зүйл хийх гэж байсан. Хөрөнгө их орох тул одоогийн байдлаар энэхүү ажлыг зогсоосон байна.

С.Даваасүрэн: Талбайн ашиглалтаа нэмэгдүүлье гэж байгаа юм байна тиймээ? Павильон хэлбэрээр засварлаагүй билүү? Задгай лангуу байгаа юу?

Я.Нэргүй: Хоёр давхар бүгд павильон байгаа.

Ц.Роза: Нэг талаасаа павильон хэлбэрээр засвар хийгээд явж байгаа.

С.Даваасүрэн: Эхлүүлээд явж байгаа юм байна. Тэрийгээ үргэлжлүүлэх гэж байгаа юм байна тиймээ?

Ц.Роза: Тиймээ.

С.Даваасүрэн: Павильон болгочихоор түрээслэгч нарын сонирхол нь арай илүү байна уу?

Я.Нэргүй: Тиймээ ая тухтай байдлын хувьд.

С.Даваасүрэн: Цоожлоод явахад амар байгаа байх

Ц.Роза: Тийм. Бид түрээслэгч нартайгаа ярилцсан байгаа.

С.Даваасүрэн: Өөр ашигладаггүй талбай нэлээн байгаа тиймээ?

Я.Нэргүй: Тэр дунд Жавхлант гээд энэ талбайд “Анхилуун”-ыг оруулаад хоёр давхар ресторан болгоно гэж бодсон арай хүч хүрэхгүй байна.

С.Даваасүрэн: Цаад талд том заал байгаа ш дээ тиймээ.

Ц.Роза: Манай “Анхилуун” урт нарийнхан болохоор ангиуд хийгээд хүүхдүүд оруулахад боломжтой, хажуудаа гал тогоотой, араараа хүүхэд ордог байхаар зохицуулах боломжтой. Гэвч ардаа машины зогсоол байдаг учир орчин нь хүүхдэд зохицохгүй юм болов уу гэж бодоод байгаа юм.

С.Даваасүрэн: Цаад талын том заал чинь том байх? Хэдэн метр квадрат билээ? Түрээсэлж байсан хоёр давхрын талбай чинь?

Ц.Роза: Хоёр мянга хэдэн зуутай байгаа байхаа талбай нь.

Я.Нэргүй: Мянга зургаан зуу ш дээ дөч дөчийн харьцаатай.

С.Даваасүрэн: Том юм байна ш дээ. Тэрийг л уг нь хүлээн авалт юмны заал болгочихмоор байгаа юм. Ашиглаад явбал.

Я.Нэргүй: Аан барааны заал биш юм. Одоо яриад байгаа “Анхилуун” нь “Жавхлант”-ын голын хэсэг хоёр давхарт байдаг талбай тэрийг л ресторан болгох гээд байгаа юм.

Ц.Роза: Манай гол хаалганы дээд талд байдаг.

С.Даваасүрэн: Аан. За ойлголоо. Тэр талбай тийм том билүү? “Анхилуун”-саа ч том уу?

Ц.Роза: Тийм. Өргөөшөө байгаа.

Я.Нэргүй: Тийм. Пилтаж маягтай.

С.Даваасүрэн: Тийм үү. Харин нэг тийм болмоор байна. Хүлээн авалтууд зохион байгуулчихдаг. Шинэлэг, орчин үеийн л болмоор байна. Бас арай л жоохон навсгар болоод байна. “Анхилуун”-ыг бол уг нь надад нийтийн хоолны газар ажиллуулбал их зүгээр санагдаад байгаа юм. Өдөр цайны цагийн үеэр хурдан түргэн сет хоолнууд гаргаад явчихдаг

газар байхад хангалттай байгаа юм. Ажиллаж байгаа ч юм шиг үгүй ч юм шиг байхаас илүү. Харин нөгөө талбайгаа бол томоороо байлгаад томоохон арга хэмжээний үед захиалгаар үйлчилдэг байвал зүгээр байна. Уг нь бол том агуулах шүү дээ. Харин зоорь чинь бол их зөв санаа юм. Гүн хөлдөөгч нь бол хэрэгтэй. Дээвэр тэгж их муудаад байна уу?

Я.Нэргүй: Дээвэр засвар хийхгүй л бол болохгүй байгаа юм.

С.Даваасүрэн: Гэхдээ мемберан биш хуучин хар цаасаар тиймээ?

Я.Нэргүй: Хар цаас биш мемберан маягийн материалаар засварласан. 2009, 2010 онд бүгдийг нь сольсон. 10 жил болж байна. Нягтлангуудад их хэцүү байгаа дээрээс нь ус гоожоод.

Ц.Роза: Дээврээ янзалж байж л доошоо орохгүй бол болохгүй байгаа. Мөн бусад аж ахуйн нэгжийн хувьд нийгмийн даатгал гэх мэт улсаас олгосон хөнгөлөлт эдэлсэн, харин манайх хөнгөлөлт эдэлж чадаагүй. Компани дөч гаруй ажилтантай байсан ч тал нь гарсан. Нийгмийн даатгал төлмөөргүй байна, улсаас төлүүлмээр байна гээд ихэнх нь гарсан. Одоо компани тал хорь гаран ажилтантай л явж байна. Энхтүвшин ирчихсэн, мэргэжлийн түвшинд ажиллаад, программуудаа суулгачихсан болохоор арай цөөхөн хүнтэй ажиллах боломж бүрдэж байна гэж харж байна. Ерөнхийдөө бол ажиллах хүч их муу байна.

С.Даваасүрэн: Багануурт хаа сайгүй л тийм байна. Ялангуяа худалдаа, үйлчилгээний салбарт.

Ц.Роза: Төлөвлөсөн ажлууд зөндөө байна. Эхний ээлжид павильоныг бол энэ жилдээ багтааж хийнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

С.Даваасүрэн: Түрээслэгчийн тоо яаж байгаа билээ? Бас буурч байна уу?

Ц.Роза: Одоо л арай гайгүй тогтворжиж байна. Яасан гэхээр бид зээл авсан. Түрээсийн байраа үзүүлж барьцаалж байгаад батлан даалт авч байгаа. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан тулдаа сэргэж эхэлж байна. Энэ онд гайгүй байх байхаа.

С.Даваасүрэн: Хөөсөн блокийн үйлдвэр байгаа билүү?

Я.Нэргүй: Байгаа, Баганууртаа л байгаа. Ажиллах хүчингүй болоод, борлуулалт зогссон байгаа.

Дөрөвдүгээр асуудал. ТУЗ-н гишүүдийг томилох.

Хурал даргалагч Я.Нэргүй: ТУЗ-ийн 8 гишүүнийг улируулан сонгож, ТУЗ-ийн гишүүн Н.Цэцэнхааныг чөлөөлж, Ж.Ганболдыг компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдийн хуралд санал дэвшүүлсэн.

С.Даваасүрэн: Ганболд гишүүнийг хаанаас санал болгосон бэ?

Я.Нэргүй: Манайхаас санал болгосон байгаа, хувийн хэвшлийн байгууллагын хүн байгаа. Бүх шаардлагаа хангаж орж ирсэн байгаа.

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээний хүрээнд ТУЗ-н гишүүдийг сонгох эрхтэй байх тул ТУЗ-н хурлаас дэвшүүлсэн нэр дэвшигч гишүүдийг ТУЗ-н гишүүдээр томилох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжин томилов.

Тавдугаар асуудал: “Хэрлэн” худалдааны төвийн дээврийн капитал их засварын ажлын хөрөнгө оруулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

Я.Нэргүй: “Хэрлэн” худалдааны төвийн дээвэр ноднин 2021 оноос эхлэн дээврээс ус гоожиж эхэлсэн. Хамгийн хямдаар мемберанан дээвэр хийхэд 245,000,000 төгрөг гэж эхлээд төлөвлөж байсан боловч одоо би энэ ажлыг 100,000,000 сая төгрөгт багтааж хийхээр ам гэрээ хийсэн байгаа. Чанар бол адилхан. Өмнөх 245,000,000 төгрөгийн төсөв нь барилгын материалын үнийн өсөлттэй холбоотой гарсан дүн юм. Одоо энэхүү засварын ажлыг хийхдээ 100,000,000 төгрөгт багтааж хийхээр төлөвлөөд байна. одоо шинээр бетон хийхгүйгээр шууд одоо байгаа бетон дээр шүршдэг мемберан ашиглаж засварын ажлыг хийх юм.

С.Даваасүрэн: Одоогоор дээвэр дээр юм байрлуулаагүй байгаа тиймээ?

Я.Нэргүй: Дээвэр дээр юу ч байрлуулаагүй байгаа.

Ц.Роза: Антен, утаснууд л явж байгаа, өөр юм байхгүй байгаа.

Хурал даргалагч Я.Нэргүй: Хуралд оролцсон ТУЗ-ийн 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн 2022 оны Бизнес төлөвлөгөөг сонсож, цаашид Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллахыг даалгасугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгож, томилсугай. Үүнд:

Ердийн гишүүд:

1. Д.Гонгор
2. Я.Нэргүй
3. Ц.Роза
4. Д.Сэржамц
5. Т.Отгонболд
6. С.Даваасүрэн
7. Н.Сүлд-Оргил
8. Б.Энххорол
9. Ж.Ганболд

Хараат бус гишүүд:

1. Д.Гонгор
2. Д.Сэржамц
3. Ж.Ганболд

5. “Хэрлэн” худалдааны төвийн дээврийн засварын ажлыг шүршдэг мемберан технологи ашиглан нийт 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх Захирал Я.Нэргүйд зөвшөөрсүгэй. дээврийн засварын ажлын санхүүжилтийг банкнаас бага хувийн хүүтэй зээл аван гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх Захирал Я.Нэргүйд зөвшөөрсүгэй.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Өмгөөллийн “Сноу Хилл Консалтанси” ХХН-ийн хуульч Ш.Цэрэндолгор, А.Солонго нарт даалгасугай.

Дээрх асуудлыг хэлэлцэж, санал хураалт явуулж дууссаны дараагаар Хурал даргалагч Я.Нэргүй хурал хаасныг мэдэгдэв. Хурал 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 16:16 цагт хаав.

ХУРЛЫН ДАРГА:



Я.НЭРГҮЙ